



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/305

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 08 ны өдрийн 24 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл нуурыг хамгаалах цогц ажлын хүрээнд “Хөвсгөл нуурын их цэвэрлэгээ” нийтийн арга хэмжээнд оролцож хог тээвэрлэсэн авто машинуудын шатахууны зардалд 1 894 560 (Нэг сая найман зуун ерөн дөрвөн мянга таван зуун жаран) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 1 894 560 (Нэг сая найман зуун ерөн дөрвөн мянган таван зуун жаран) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П. Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш. ИДЭРБАЯСГАЛАН